



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

┌ Хорооны 2008 оны 157 дугаар тогтоолоор ┐  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-д доор дурдсан агуулгатай дараах 1 дүгээр зүйлийн 1.6, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.3, 2.2.4, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.5, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4.2.8 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

**1/ 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэг:**

“1.6 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх ББСБ-д жилд 1-ээс доошгүй удаа газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.”;

**2/2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.3, 2.2.4 дэх заалтууд:**

“2.2.3. Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахдаа Хороонд мэдэгдэж, бүртгүүлсэн эсэх, холбогдох журмын шаардлагыг хангаж байгаа эсэх;

2.2.4. Хаалттай өрийн бичиг гаргахдаа Хорооноос зөвшөөрөл авсан эсэх, Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэх”;

**3/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.5 дахь заалт:**

“3.1.5. Нийт активт эзлэх үндсэн хөрөнгийн хэмжээ”;

**4/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4.2.8 дахь заалт:**

“4.2.8. Мөнгө угаах терроризмтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэх”.

000907

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.2, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.4, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалтын “в/”-г доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.2 дахь заалт:**

“2.2.2 Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан эсэх, хувь нийлүүлсэн хөрөнгийн бүрдэл нь Хорооноос гаргасан тогтоол, шийдвэрт нийцэж байгаа эсэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тухай бүр Хороонд мэдэгдэж зөвшөөрөл авч байсан эсэх;”

**2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.4 дэх заалт:**

“3.1.4 Өөрийн хөрөнгөд эзлэх активын төвлөрлийн эрсдэлийн хувь хэмжээ;”

**3/ 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

**“5.1 Үндсэн ба чанарын хүчин зүйл**

Ашигт ажиллагааны чанарыг үнэлэхдээ ашигт ажиллагааны түвшин, хандлага болон тогтвортой байдал, ашигт ажиллагааны зах зээлийн эрсдэлээс хамаарах хэлбэлзэл; эрсдэлийн сангуудын зохистой түвшин, гэнэтийн орлого зарлагаас хамаарах ашигт ажиллагааны хамаарал зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэнэ.”;

**4/ 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалтын “в/”:**

“6.2.1. в/ Итгэлцэлийн үйлчилгээ, хоёрдогч өглөг болон хаалттай өрийн бичиг гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос баталсан журам, зааварт заасан шаардлагыг хангасан эсэх”.

3. Мөн журмын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4.2.2 дахь заалтын “... эсэх,” гэсний дараа “... гүйцэтгэх удирдлага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;” гэж, 4.2.4 дэх заалтын “...тавьдаг;” гэсний дараа “... Монголбанкны зээлийн мэдээллийн санд холбогдсон эсэх;” гэж, 4.2.7 дахь заалтын “Санхүүгийн...” гэсний өмнө “Нятлан бодох бүртгэлийн программ хангамжтай эсэх,...” гэж тус тус нэмсүгэй.

4. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 1.2, 1.5 дахь хэсгүүд болон 2 дугаар зүйлийн “... мэргэжилтэн...” гэснийг “...хянан шалгагч...” гэж, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2.1.1 дэх заалтын “...нийт цэвэршүүлсэн...” гэснийг “...эрсдэлээр жигнэсэн...” гэж, 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 8.3.2 дахь заалтын “...хүндрэл үүсч болзошгүй” гэснийг “...цаашид хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсгийн “...тодорхойлох хүчин зүйлс буюу...” гэснийг, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.1 дэх заалтын “...дүрмийн сантай...” гэснийг, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4 дэх заалтуудын “...байвал зохих...” гэснийг, 2 дахь хэсгийн 3.2.2 дахь заалтын “в/”-ийн “Хоорондоо...” гэснийг, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7.2.2 дахь заалтын “б/”-ын “Эрсдэлийн эх сурвалж болон уялдаа холбоог судалж...” гэснийг тус тус хассугай.

6. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2.1 дэх заалтын “а”, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалтын “д”, “е”-г тус тус хүчингүй болгосугай.

7. Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН